

Алдаатай удирдлага

Фермер Жон програмчилж болдог шинэ трактор худалдаж авчээ. Уг трактороо хөдөлгөхийн тулд тэр N ($1 \leq N \leq 10^5$) урттай зөвхөн "F", "R", "L" буюу чигээрээ, баруун, зүүн гэсэн 3 төрлийн өгөгдлөөр ажиллана.

"F" нь чигээрээ 1 нэгж явах бол "R" нь баруун тийш "L" нь зүүн тийш 90 градус эргэнэ.

Тракторын анхны байрлал нь координатын эх $(0, 0)$ цэг дээр хойд зүг рүү харж эхэлнэ.

Фермер Жон трактороо програмчилж байхдаа тэмдэгт мөрөнд яг 1 ширхэг тэмдэгт алдсан гэдгээ мэджээ.

Жишээ нь тэр "R" тэмдгийг алдаад "F" эсвэл "L" гэж бичсэн байж магадгүй юм. Тэр яг аль тэмдгээ алдсанаа санахгүй байгаа болохоор түүний яг зөв байрлал хэдэн ялгаатай газар төгсөж болох вэ?

(Замынхаа төгсгөлд аль зүг рүү харж дуусах нь ялгаатай гэж тооцохгүй.)

ОРОЛТ

Нэг мөрөнд Фермер Жонын бичсэн тэмдэгт мөр.

ЖИШЭЭ ОРОЛТ

FF

ГАРАЛТ

Нэг мөрөнд тракторын очиж болох ялгаатай байрлалуудын тоо.

ЖИШЭЭ ГАРАЛТ

3

ТАЙЛБАР

Тэр 4 өөр үг бичсэн байж болно: "FL", "FR", "LF", "RF". Эдгээр нь харгалзан $(0,1)$, $(0,1)$, $(-1,0)$, $(1,0)$

гэсэн цэгүүд дээр буюу 3 ялгаатай байрлалд очиж болно.

Орчуулсан : УБ 1-р сургуулийн 12-р ангийн сурагч Б.Мөнх-Оргил